



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 3 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар А/130 ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүн амын хөгжлийн газар /С.Тунгалагтамир/, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /О.Алтансүх/-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/-т даалгасугай.

САЙД

С.ЧИНЗОРИГ

<https://www.legalinfo.mn/law/details/14312>